



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

14251 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
II хороо, Чингисийн өргөн чөлөө 11
Утас: 62263168, Факс: (976-11) 31-23-15
И-мэйл: info@mrt.d.gov.mn, <https://www.mrt.d.gov.mn>

2016.10.21 № *38-07-003/08*

**АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗАР-Т**

**Стандартын шаардлага
хангасан эсэх тухай**

“Тал нутгийн хэрлэн” ХХК-иас “Зөрчил арилгасан тухай” 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 42 дугаар албан бичгээр ирүүлсэн холбогдох материалыг үндэслэн тухайн компанийн боловсон хүчинд тавигдах стандартын шаардлага хангасан эсэхийг шалгалаа.

Товч мэдээлэл:

Танай газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Тал нутгийн хэрлэн” ХХК-ийн танилцуулга болон холбогдох материалыг үндэслэн тухайн компанийн боловсон хүчин, материаллаг бааз, тээврийн хэрэгслүүд стандартын шаардлага хангасан эсэхийг шалгаж, автотээврийн хяналтын улсын байцаагчийн 38-07-003/05 дугаар дүгнэлт гарсан.

Уг дүгнэлтээр “Тал нутгийн хэрлэн” ХХК-ийн тээврийн асуудал эрхэлсэн инженер, техникийн ажилтан, тээвэрлэгч жолооч нар нь мэргэшсэн инженерийн болон улс хоорондын зорчигч тээврээр мэргэшил дээшлүүлээгүй нь “Улс хоорондын автотээврийн ачаа, зорчигч тээвэрлэлт. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага” MNS5831:2007 улсын стандартын 5.7/Улс хоорондын автотээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь автотээврийн салбарын мэргэжилтэй ажилтнаар хангагдсан байна. Инженер, техникийн ажилтан, жолооч нар нь ажил үүрэг, мэргэжлийнхээ чиглэлээр холбогдох мэргэшүүлэх сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна;/ 11.2 дахь/Улс хоорондын автотээврийн аж ахуйн нэгж байгууллагын дарга нь зөвлөх инженерийн, алба хэлтсийн дарга, ерөнхий мэргэжилтнүүд нь мэргэшсэн инженерийн сургалтад хамрагдан, гэрчилгээ авсан байна/ заалтыг тус тус хангахгүй гэж дүгнэгдсэн.

Тодорхойлсон нь:

1. Тээвэр хариуцсан захирал Ц.Батбаатар: Инженер механик мэргэжилтэй, “Хөдөлгөөн зохион байгуулалт, хөдөлгөөний аюулгүй байдал”-ын хүрээнд мэргэшсэн инженерийн зэрэгтэй. Гэрчилгээний № 14-836.

2. Тээвэрлэгч жолооч Б.Мөнхбат, Г.Жамбаа, А.Түмэнбаярхүү нар нь улс хоорондын зорчигч тээврээр мэргэшил дээшлүүлсэн.

Дүгнэх нь:

08 063

Инженер, техникийн ажилтан, жолооч нар нь ажил үүрэг, мэргэжлийнхээ чиглэлээр холбогдох мэргэшүүлэх сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байгаа нь Улс хоорондын автотээврийн ачаа, зорчигч тээвэрлэлт. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага" MNS5831:2007 улсын стандартын 5.7, 11.2 дахь заалтуудыг бүрэн хангасан байна.

АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ



Э.ОЮУНТУНГАЛАГ